



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/10

Хэрлэн сум

Санхүүгийн гүйлгээ баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" 318 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан нөөц хөрөнгийн санхүүгийн гүйлгээний баримтын 1 дүгээр гарын үсгийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, 2 дугаар гарын үсгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нар тус тус зурж баталгаажуулж байхаар тогтоосугай.

2. Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг журамд заасны дагуу гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байхыг тухайн арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэсэн байгууллага, ажилтан нарт даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА